



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА
Дугаар 34

2017 оны 06 сарын 14 өдөр

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Баянхонгор Ойжуулалт” хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. 2015 онд уул уурхайн нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, ААН-ээс өгсөн 208,3 сая төгрөгийн хандиваар хиймэл нуур, услалтын системийн шахах хоолой угсрах ажлыг гүйцэтгэсэн бөгөөд тус ажилд гүйцэтгэлээр нийт 206,1 сая төгрөгийг зарцуулсан байхад 14,5 сая төгрөгийг авлагаар тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 20.2.5 дахь “Ерөнхий нягтлан бодогч нь дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах үүрэг хүлээнэ” гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.1-т заасан “Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. 2017 оны эхний хагас жилд багтаан 14,5 сая төгрөгийн авлагыг залруулах

2517037

2. Албан шаардлагын биелэлтийг 2017.06.30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг "Чанмань-Баянхонгор" ХК-ийн захирал Э.Энхбат, ерөнхий нягтлан бодогч Б.Наранцэцэг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ		
АУДИТОР АУДИТОР		Б.ДОЛЖМАА П.МӨНХ-ЭРДЭНЭ
ЗАХИРАЛ ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ		Э.ЭНХБАТ Б.НАРАНЦЭЦЭГ

¹. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.